

ДУНДГОВЬ - 2010

/ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД/

Дундговь аймаг 2010 онд зохион байгуулж үр дүнд хүрсэн дараах ажил арга хэмжээнүүдийг онцлох үйл явдлууд хэмээн нэрлэж байна. Ирэх онд тохиох Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 70 жилийн ойн урьтал жил гэдгээр 2010 он ой угтсан бүтээн байгуулалтын их ажил өрнөж эхэлсэн жил байлаа.

1. ДУРСАМЖ, ДУУ ХУУР ХӨГЛӨГДСӨН СОЁЛ УРЛАГИЙН ӨДРҮҮД



Дуу хуурын өлгий нутгийнхан урлаг соёлын өдрүүдээ эх орны нийслэлд зохион байгуулсаныг Дундговь аймагт тохиосон 2010 оны онцлох үйл явдлын тэргүүнд нэрлэж байна.

Тэртээ 1984 онд Дундговь аймгийнхан соёл урлагийн арав хоногийг Улаанбаатар хотноо зохион байгуулж байсан бол 22 жилийн дараа буюу 2006 онд урлаг соёл, бизнесийн өдрүүд болгож нийслэлд зохион байгуулсан билээ. Энэ нь зах зээлд шилжсэнээс хойш бусад аймгуудыг түүчээлсэн анхдагч үйл явдал

байсан юм.

Нутаг нэгтнүүд маань учран уулзаж, дурсамж дурдатгал хүүрнэн, дуу хуураа хөглөж, нутаг амьтай халуун сэтгэл хөврүүлсэн энэ өдрүүдийг Улаанбаатар хотод дахин зохион байгуулсан юм.

Энэ үеэр “Дуундаа жаргасан нутаг минь” бүрэн хэмжээний концерт, төрийн соёрхолт ардын уран зохиолч Бавуугийн Лхагвасүрэнгийн “Гэгээн тамлан” жүжиг, хүүхдүүд “Ботгон эгшиг” концерт, Дамбын Төрбатын зохиол “Тэнгэрийн тэмдэг” жүжгээ Улаанбаатар суугаа нутгийн унаган иргэддээ өргөн барьсан юм. , “Дундговь нутгийн өв соёл” үзэсгэлэнгээр аймгийн музейн 467 шилдэг үзмэр, сумдын 447 үзмэр гаргалаа. Урлаг соёлын өдрүүдээ нийслэл хотод зохион байгуулах нь дуу хуурын өлгий нутаг гэдэг эрхэм алдрыг өндөрт өргөж явах, урлагийн өв соёлоо залуустаа уламжлуулах гол зорилгыг агуулдаг билээ. Энэ удаагийн тоглолтод нийт 300 гаруй авъяастан оролцсон юм.



2. ТЭРГҮҮНИЙ МАЛЧИД ЗӨВЛӨЛДӨВ



Монгол орны мал аж ахуйд ихээхэн хэмжээний хохирол учруулж одсон өнгөрсөн өвлийн зудыг малч арга ухаан, ажилсаг чанараараа гарз хохиролгүй давж чадсан малчдыг оролцуулан Дундговь аймаг тэргүүний малчдынхаа зөвлөгөөнийг зохион байгуулав.

Аймгийн нийт малчдын 68.1 хувь мал сүргээ ихээр хорогдуулж, малаа хорогдуулсан малчдын 61 хувь нь огт малгүй болсон бол малаа зуднаас хамгаалж чадсан 2000 гаруй малчин байсан юм. Тэдний арга туршлага,

ажилсаг зан чанарыг бусдад дэлгэрүүлэх нь цаашид ч тохиосоор байх байгалийн эрсдэлд малчдыг бэлтгэхэд ихээхэн тустай байлаа. Малчид дор бүрнээ л өөр өөрийн арга туршлагаа ярьцгааж, энэ зөвлөгөөн үр дүн, үнэ цэнэтэй болсон юм.

- “Бизнесийн орчны шинэчлэл, залуучуудын оролцоо” аймгийн залуу мэргэжилтний 4 дүгээр чуулганыг зохион байгуулж нийт бизнес эрхлэгч залуучууддаа хандаж зөвлөмж гарган хэрэгжүүлж байна.

3.ОЮУТ ОВООН ОРДОД ТОМООХОН ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ЭХЛЭВ

Ашигт малтмал, уул уурхайн салбараа түшиглэн хөгжлийнхөө тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон Дундговь аймагт энэ жил уул уурхайн нэгэн үйлдвэр шинээр үйл ажиллагаагаа эхлүүлэхээр бүтээн байгуулалтаа эхлэв.

Дундговь аймгийн төвөөс 73 километрт Эрдэнэдалай сумын нутагт оршдог төмрийн хүдрийн нөөцийг ашиглахаар “Голден погода” ХХК эрхэмжээ авчээ. Оюут овоо хэмээн нэрлэсэн энэ газарт “Азия голд Монголия”ХХК хайгуул хийж, нөөцийг эхний байдлаар 2.5 сая тонн гэж батлуулсан бөгөөд нарийвчилсан хайгуул хийвэл нөөц нь 20 сая тоннд хүрэх боломжтой юм байна. Энэ томоохон ордыг ашиглах “Голден погода” ХХК нь Гонконгийн зуун хувийн хөрөнгө оруулалттай уул уурхайн NAR группын эзэмшил бөгөөд тус групп Монголоос гадна Казакстан, Зүүн Сибирт уул уурхайн төсөл хэрэгжүүлдэг ажээ.

Оюут овоогийн ордыг түшиглэж буй баяжуулах үйлдвэр энэ оны эхний хагаст үйлдвэрийн бүтээн байгуулалтыг өрнүүлж эхэлсэн нь энэ оны уул уурхайн салбар дахь онцлох бүтээн байгуулалт болов.

Өнөөдрийн байдлаар энэ уурхай орон нутгаас 25 иргэнийг ажлын байртай болгосон агаад цаашдаа үйлдвэрлэлээ эхлэхээр ажлын байрыг нэмэгдүүлж 2014 он гэхэд 130 ажлын байрыг орон нутагт гаргахаар төлөвлөжээ. Орон нутгийн төсөвт оруулах татварын орлогыг 200 мянган тонн тутмын нэг тонныг 80 доллар гэж үзвэл үүний арван хувь буюу 1.6 сая доллар гэж тооцож байгаа юм байна.

4.ХҮҮХДИЙН ПАРКИЙГ БАРЬЖ ЭХЛҮҮЛЭВ.



Энэ оныг хүүхдийн төлөө бүтээн байгуулалтын жил болгон зарлаж аймаг, сумын хэмжээнд гэр хороолол, гудамж талбайд 27 сүүдрэвч, 103 хүүхдийн тоглоомын талбай, сум бүрт хүүхдэд зориулсан номын сан, сүүний цех, хүүхдийн кафе, хүүхдийн номын болон хүнс, хувцас, тоглоомын төрөлжсөн дэлгүүртэй болж, жилийн ажилд улс, аймаг, орон нутаг, төсөл хөтөлбөр, иргэдийн хандив тусламжийн санхүүжилтээр нийт 2,5 тэрбум

төгрөгний хөрөнгө оруулалт хийснээс сургууль цэцэрлэгийн их засвар, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэхэд 2,2 тэрбум төгрөгийг зарцуулж, хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг сайжрууллаа. Энэ бүтээн байгуулалтын хамгийн том нь хүүхдийн парк. Оны эхэнд шавийг нь тавьж, урь унангуут бүтээн байгуулах ажил нь эхэлсэн хүүхдийн парк Мандалговь хотын зүүн хойд дүүрэгт хорин га газрыг эзлэн сүндэрлэж байгаа.

Мод, цэцэрлэгжүүлэлт, зам талбай, барилга, хашаа хайс, гэрэлтүүлэгтэй, хүүхдийн задгай театр, монгол зан заншлийн өргөөтэй, гэрэл цахилгааны дэд станц, төвлөрсөн усан хангамжтай, жимс жимсгэнийн бут, ойн төгөлтэй гээд дурьдах томоохон бүтээн байгуулалт бүхий хүүхдийн парсад алсыг харагчаас эхлээд хүүхдийн парсад байх ёстой бүхий л тоглоомыг суурилуулж эхэлсэн. Хүүхдийн паркийг бүтээн босгоход 370 сая төгрөгийн хөрөнгө оржээ. Энэ хөрөнгийг аймаг хөгжүүлэх сан болон Дундговь аймагт уул уурхай, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, компаниудын хандиваар бүрдүүлсэн. Паркийг 6 сард нээн ажиллуулна.



5. МАНДАЛГОВЬ УЛААНБААТАРЫН ЗАМЫГ БАРЬЖ ЭХЛЭВ



Олон жилийн турш Дундговь аймгийнхны хүсэн хүлээсэн Улаанбаатар, Мандалговийн чиглэлийн хатуу хучилттай замыг энэ онд барьж эхлэв.

Улсын төсвийн 3 тэрбум төгрөг, УИХ-ын гишүүн Наранхүү, Раш нарын багцаас 1.5 тэрбум төгрөгийг гарган, нийт 4.5 тэрбум төгрөгөөр Мандалговиос эхлүүлэн Улаанбаатарын чиглэлд 15 километр зам барихад зарцуулав.

6. ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭС ҮЙЛ АЖИЛЛАГААГААРАА УЛСАД ТЭРГҮҮЛЭВ.

Хууль тогтоомж, шийдвэрийг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлыг тогтмолжуулан, иргэдийн эрх зүйн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлж, хуулийн байгууллагуудын хөрөнгө оруулалт нэмэгдэж, гэмт хэргийн тоо, холбогсодын тоо өнгөрсөн оноос буурсан зэрэг ажлын үр дүнгээрээ аймгуудаас тэргүүн байранд, мөн “Эрх зүйн туслалцааны төв” нь хүний эрхийн өдрийг угтаж зохион байгуулсан уралдаанд тэргүүн байранд тус тус шалгарч ХЗДХЯ-ны өргөмжлөл, мөнгөн шагнал, эрх зүйн лавлагаа, мэдээлэл бүхий номын сангаар шагнууллаа.



7. “ШУДАРГА ЁС, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭГЧ АЙМАГ” БОЛОХ ЗОРИЛТ ТАВИВ.

Төрийн албан хаагч бүр өргөсөн тангарагтаа үнэнч байж, авлига, хээл хахуультай тууштай тэмцэж, ёс зүйг мөрдөн, хуульд захирагдан, шударга ёсыг

эрхэмлэн ажиллах нь Дундговь аймгийн нийт төрийн албан хаагчдын үндсэн үүрэг гэж үзэн “Шударга ёс, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг эрхэмлэн дээдлэгч аймаг” болох зорилтыг тавьж “Авлигатай тэмцэх олон улсын өдөр”-өөр ард иргэддээ хандан шударга ажиллахаа илэрхийлж, Мэдэгдэл гарган хэрэгжүүлж байна.

8. ЗҮГЭЭР Ч НЭГ ИХ ЦАС БИШ ГАМШИГ БАЙЛАА



Малчдын ярьж байснаар сүүлийн хориод жил үзэгдээгүй их цас өнгөрсөн өвөл Дундговь аймгийн нутагт унаж, мал аж ахуйд ихээхэн хэмжээний хохирол учруулсан нь 2010 оны гамшигт үйл явдал байлаа. 2009 оны эцсийн мал тооллогоор Дундговь аймаг мал сүргээ 98 мянган



толгойгоор өсгөж, 2 сая 138 мянга 924 толгойд хүргэсэн амжилттай байсан юм. 2010 оны босгон дээр Дундговь аймгийн нийт нутгийг хамарсан хүчтэй цасан шуурга ихэнх нутгаар 18- 24 метр секунд, хамгийн хүчтэй нь Адаацаг сумын нутагт секундэд 30 м, Дэрэн сумын нутагт секундэд 28 м хүрч ширүүссэн нь өвөлжилтийг гамшигийн нөхцөл байдалд оруулсан юм.

Өнгөрсөн өвлийн зуднаар аймгийн 4857 малчин өрх 829 мянга 356 толгой малаа хорогдуулж, зах зээлийн дундаж үнээр үнэлэхэд малчдад 45.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан. Энэ нь нийт малчин өрхийн 68. 1%, оны эхэнд тоолуулсан малын 38.6% болов.

9. ХҮҮХДИЙН ТЕАТРЫНХАН ХҮҮХДИЙН ОРОЛЦООТОЙ АНХНЫ ШИЛДЭГ ЖҮЖГИЙН ЭЗДЭЭР ТОДРОВ.



Хүүхдийн театр нь Аймгийн Засаг даргын 2009 оны 102 дугаар захирамжаар Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд байгуулагдсан билээ. Байгуулагдсанаас хойш хүүхдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, авъяас чадварыг хөгжүүлэх зорилгоор морин хуур, уртын дуу, найрал дуу, зохиолын дуу, хүүхдийн жүжиг, гар зураг, ардын бүжиг, үндэсний хөгжим зэрэг 17 төрлийн дугуйлан хичээллүүлж 150 гаруй хүүхдийг хамруулаад байна. Тус хүүхдийн

театрын жүжгийн дугуйлангийн хүүхдүүд “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн жүжгээрээ “Гэгээн Муза-2010” улсын уралдаанд амжилттай оролцож анхны “Хүүхдийн оролцоотой шилдэг жүжиг” наминацид шалгарч “ГЭГЭЭН МУЗА” цом, өргөмжлөлийг гардан авлаа.

10. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ШИНЭЭР ТОМИЛОГДОВ.

Дундговь аймгийн Засаг даргаар зургаа дахь жилдээ ажиллаж байсан Шоотонгийн Төрбат эрүүл мэндийн шалтгаанаар аймгийн Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх тухай хувийн хүсэлтээ гаргаж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит 7 дугаар хуралдаанаар аймгийн Засаг даргыг шинээр томилох тухай хэлэлцэж, аймгийн

ИТХ- д олонхи суудалтай МАХН- ын хорооноос Дамбабазарын Чандманы нэрийг аймгийн Засаг даргад дэвшүүлж, иргэдийн хурлын төлөөлөгчдийн 91. 6 хувийн саналаар түүнийг дэмжин, Засаг даргаар томилон ажиллуулах саналыг Монгол улсын Ерөнхий сайдад өргөн барьснаар Ерөнхий сайд батламжилсан юм. Дундговь аймгийн ард иргэд ч оюунлаг, ном эрдмийн хүн аймаг орон нутгаа удирдах болсныг талархан хүлээж авсан юм.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР